

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ**[20 оноо]****Санамж:**

1. Эхийг анхааралтай уншин асуулт даалгавар бүрийг гүйцэтгээрэй.
2. Сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиллаарай.
3. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг дугуйлаарай.
4. Даалгавар бүр 2 оноотой.

Сүнсэнд шингэсэн гэмшил /өгүүллэг/

Сэдваанчиг, Сэрээдэнэ хоёр дөрвөн ханатдаа утаа уугиулж дөнгөхөө болив. Нас гэж талийсан хоёр. Аргагүй л ийм болдог хорвоо байж. Эмгэн "Дулаан газар өвөлжинө" гээд охиныдоо төвлөж, өвгөн уулын мухрын өвөлжөөнд, отгон хүүгийн дээ хоцорчээ. "Малын амьсгаа, хөх өтгөнөөсөө хол үхэхгүй" гэж Сэдваанчиг бөглөрөх гэж буй мэнгэртэй цээж хяхтнуулжээ. Аравдугаар анги дүүргээд сургуулиас завсардсан хоёр ач нь, отгон хүү бэр хоёрт нь бүл болохоор тэднийд өвгөнтэй хамт өвөлжив. Хоёр ач, отгон хүү бэртэйгээ Сэдваанчигт тун сайхан. Гэхдээ насыг хамт элээсэн эмгэнээ сэмхэн их үгүйлнэ. Тэрсхэн хоёр ач нь дүрсгүйтэх нь ядарсан өвгөнд халгаатай ч, "тэсвэрлэе" гэж хатуу шийдсэн учир нүд аньж, эрх эргүүлсээр өдрийг барна. Хааяа амсхийх зуур хоёр ачдаа бөх ярьж, шилээ шөргөөж, цээж ханхалзуулах санаатай. Уг нь мань эр залуудаа бузгай барилдаж, сумын наадамд түрүүлж байсан агаад бяр нь багтахгүй бөх болж харагдахын тулд хоолойгоо шахаж бүдүүн дуугарах, их идэх гэж мангарлах, мөн бөхөрхүү алхаа гишгээгээр алцганаж явсан нас түүнд бий. Зөнөг өвөөгөө уйдсан хоёр ач нь ёргино. Өвгөн янхир араг яс хэрэгнүүлснээ юм бараг үзэхээ больсон мөндөр шиг хоёр цэхэр нүдээр ач нарынхаа бие бялдрыг шинжлэн гөлөрч гөлөрч:

-Та муу хоёр солигт уг нь бөхийн удам гарцаагүй байх ёстой сон гэж сөөнгөтөхөд эцэнхий нүүрт нь удахгүй учрах үхлээ мартсан баяр гийх агаад архаг мэнгэрийн цэр дүүрсэн цээж удахгүй унтрахын дохио юу гэлтэй, ой гутам хэржигнэснээ нэгэн битүүхэн дорой авиа болон тээр цааш хяхтнасаар завхрав.

Өвгөн гэр дулаацсан хойно яарамгүй өндийнө. Нэг өглөө хоёр ач нь малдаа явахын өмнө дундаа түмпэнтэй мах тавьчихсан идэж сууснаа хоорондоо шивнэлдэж, хөхрөлдөөд байх юм. Өвгөн сэм харвал бөхийн удамт нөгөө хоёр чинь үхрийн бадируун сээр хуга шаах гэж буй бололтой. Ээлжлээд л нөгөө сээрийг нүцгэн нударгаараа дэлсэх юм. Сээр хугардаггүй ээ. Дахиад л гөвших юм. Өвгөн "Зөв! Дахиад сайн шаа!" гэж сэм дэмжив. Нөгөө хоёрын гар нь өвдсөн бололтой "ёо ёо" гээд гараа үлээцгээн, унан тусан хөхрөлдөж хөхрөлдөж, сээрээ хугалж дийлэлгүй гарцгаав. Өвгөн "Эвий нь л олсонгүй дээ. Тэрнээс биш сээр хуга шаадаг л юм гэсэн. Би тэгж сээр хугалж үзээгүй ээ. Хоёр хүү минь эвий нь л олсонгүй. Миний удамд сээр хуга шаах хүү заавал байх ёстой сон" гэж хэвтлээ.

Сэдваанчиг босож, бэрийнхээ гарын цайг зооглож, цагаан тос, зөөлөн боов шүдгүй амандаа маймарч сууснаа түмпэнтэй мах авч, амандаа үмхчихмээр зөөлөн юм эргүүлдэв. Тэгтэл хоёр ачийнх нь хугалж дийлээгүй мөлжүүртэйгээ үхрийн сээр нүдэнд тусжээ. Өвгөн сээрийг авч, эргүүлж тойруулж үзсэнээ хэрэгэр том ясан гараараа дэлсэж орхитол сээр хуга үсрээд, хоёр хэсэг болон түмпэнд тонхийн ойчив. Бэрийнх нь нүд орой дээрээ гарснаа:

-Аав аа, та яасан мундаг юм бэ гэж дуу алдахад Сэдваанчиг додигорхон жуумалзсан боловч, бярддаа таарсан хариу үг олсонгүй.

Эзгүй ууланд өвөлжингөө уйссан бэр, гадаа үхрийн зэл цэвэрлэж буй хоёрт, зэлүүд нутагт ховор юмны нэг, хөгжилтэй мэдээ дуулгаж, баясгахаар нөгөө хугархай сээрийг нэг нэгээр нь хоёр гартаа олимпын бамбар мэт мандуулсаар гарч гүйлээ.

Өвгөн их маадгар "Хоёр ачийгаа хугарсан сээр үзээд яах бол?" хэмээн "хэ хэ" гэсээр хоцров.

Зэлний хүйдэс хамж байсан нөгөө хоёр луу бэргэн гүйж очоод сээрээ үзүүлж:

-Та муу хоёр үүнийг хар! Намайг харж байхад аав ганцхан шаагаад ингээд хоёр хэсэг болгочихлоо гэвэл нөгөө хоёр үхтлээ инээж:

-Үгүй ээ! Наад сээрийг чинь, бид хоёр өвөөд мэдэгдэлгүй төмрийн жижиг хөрөөгөөр сэм хөрөөдөөд, арай салгалгүй хөрөөдсөн газраа өөхөөр сайн шаваад тогтоочихсон юм. Харин та өвөөд битгий хэлээрэй! Бид хоёр өвөөгөө баярлуулах гэсэн юм гээд хоёул гэрт уралдан гүйж орлоо. Тэгээд бөх өвөөдөө:

-Өвөө та ямар мундаг юм бэ? Та яаж тэр үхрийн сээрийг хуга шааж чадав аа? Бид хоёр таван сарвуугаа бяцартал зөндөө гөвшөөд хугалж дийлээгүй юм шүү дээ?! гэвэл өвөө нь баяртайгаар:

-Юманд чинь эв гэж бас байдаг юм! Дан хар бяраар бөх болохгүй шүү гэж сургамжилсан харцаар мялаажээ.

Уйдсан дүрсгүй хоёр ач нь "Өвөө та одоо ийм бяртай байгаа юм чинь залуудаа ёстой аварга бөх байсан байх аа" гээд толгой сэгсрэн магтлаа! Хоёр ачийнхаа магтаалыг Сэдваанчиг сонсоод



сэтгэл нь хөөрсөндөө умс шиг хөх нүүрээ үрчийлгэн уйлах дөхөв. Ач нарынх нь хоолой зангирсан хэдий ч, "Манай өвөө гартаа ямар аймаар хүчтэй юм бэ?" гэж шогширсоор. Өвөө нь хөөрч хэнхэлзсээр. Үндсэндээ тэр гурав ийнхүү наргиж, урт өвлийг барж буй билээ.

Хавар болж, газрын дор бууж, дулаарч, тараг сүү дэлгэрэх үед эмгэн Сэрээдэнэ хөдөөлж, хоёр биеэ санасан өвгөн эмгэн хоёр дөрвөн ханатаа юуны түрүү овойлгов. Хоёул тусдаа амьдрах нэг л ондоо. Сүүлийн жилүүдэд хоёул яльтай яльгүй юмнаас болж үг сөргөлцөж, муудалцах, тэр ч байтугай, хэрэлдэх болсон гээч. Өвлийн хэдэн сарыг тус тусдаа өнгөрөөсөн хоёр хөгшин бие биедээ их л эелдэг хэд хонов.

Тэгтэл хэрэг бишидлээ. Олон хүүхэд, ач зээ нараасаа болж тэр хоёрын хэрүүл үүсдэг юм. Бас л тэгжээ. Өвгөн хэнийг зэмлэж, хэнийг буруутгана, тэр болгоныг эмгэн тас өмөөрнө. Өвгөнд энэ нь их лайтай. Эмгэн ямагт өвгөнийг үгүйсгэж, хүүхдүүдээ зөвтгөнө. Хүүхдүүдээ дэс дараалан зөвтгөж, өвгөн тэр болгонд, дэс дараалан буруудна. Хэрүүл ингэж цааш үргэлжлэхэд, эцэстээ өвгөний тэвчээр барагдаж, уур нь оргилж, байх суух газраа олж ядна. Уухилна. Оволзоно. Хүүхэд бүрээ зөвтгөж, өвгөнийг буруутгах гэж ухаангүй улайран зүтгэх эмгэндээ хэлэх муу үг олсонгүй. Дэмий л:

-Чи муу төрийн хутгуур гэж цоллов.

Хамгийн муу үгээ цээрлэлгүй хэлж, өшөөгөө авч буй нь тэр.

Хэрүүл дээр санаандгүй орж ирсэн отгон хүү нь, эргэнэг хавиар идэж уух юм хайнгаа, хоёр бие рүүгээ давшлан хэрэлдэж буй зөнөг эцэг эх хоёрыгоо харж харж:

-Яваад бай, яваад бай! Давшаад бай, давшаад бай гэж ташуур өгч, тохуурхаад гарч одов. "Төрийн хутгуур" гэсэн үгний учрыг эмгэн сайн олоогүй ч сүрхий хорсжээ. Хэрүүлд улангасахаараа давахын төлөө хамгийн муухай хорон үг олж хэлэх гэж хорхойсдог эмгэний удмын гажиг сэдэрч:

-Чи өөрийгөө их сүрхий хүн гэж бодож байна уу? Тэр үхрийн сээрийг чинь, хоёр ач чинь төмрийн хөрөөгөөр хөрөөдөж, хөрөөдсөн ормоо царцуу өөхөөр шавж тогтоогоод чамайг дамшиглах гэж түмпэнд тавьчихсан юм гэсэн шүү, зөнөг толгойт оо! Чи муу хөрөөдсөн сээр хуга шаачхаад, зөнөгөө мэдэхгүй онгирч, хүүхдүүдийнхээ элэг доог болсноо одоо мэдэж ав!.. Хэлэх үггүй болов уу, хэрүүлч ээ?... Ичиг, ичиг гэж хорыг нь малтав.

Өвгөн нэг л хачин, сэжигтэй, таг чимээгүй болчихсон гэнэ. Тэр дахиж үг унагасангүй. Хэвтээд өгч. Удалгүй өвгөний лагшин гэнэт чилээрхэв. Хамгийн аймшигтай нь өвгөн буруу харж хэвтчихээд дуугардаггүй. Эмгэн ухаангүй сандарлаа. Эр хүнийг эр чадлаар нь басамжилна гэдэг ийм аюултай ажээ. Сүүлдээ цөхөрсөн эмгэн өвгөндөө "Тэр сээр чинь хөрөөдөөгүй сээр байсан юм. Би ууртаа чамайг дийлэх гэж хөрөөдсөн сээр гэж худал хэлсэн юм" гэж аргадсан боловч Сэдваанчиг бас л дуугарсангүй. Өвгөн нь, тиймхэн зальд хууртагдахаар хүн биш гэдгийг Сэрээдэнэ чавганц дэндүү сайн мэдэх тул яаж ч чадахаа болилоо.

Өвгөн дуугарахгүй буруу харж хэвтсэн чигтээ хэд хоноод ерэн насандаа амьсгал хураав. Эмгэн орилоод салдаггүй. "Би юунд тийм хэрэг хийв ээ?" гэж уйлаад, гэртээ хүн ороход дургүйцэж, гав ганцаар мэгшихийг хичээнэ. Хөөрхий тэр чавганц, бас удахгүй бололтой. Өвгөнөө гомдоогоод явуулчихсан. Өвгөн нь ганц удаа ч эргэж хараагүй. Ганц үг ч хэлээгүй. Ийм их харууслыг өтөл эмгэн даахгүй нь түмэн зөв. "Явах" гэж морио эмээллэхсэн өвгөнд хөндлөнгийн ялимгүй шалтаг таарвал түүнийг аваад залрах эгзэгтэй мөч отоож байсныг эмгэн анзаарсангүй. Өчүүхэн утсанд амь нь дөнгөж торж байсныг мэдсэнгүй. Эмгэний харуусал зүрхтэйгээ цуг мөхдөг болов уу, эсвэл сүнсэнд нь шингээд, хойд насанд нь буухиалдаг болов уу?.. Яадаг бол?.. Тэнэг тоглоом оо гэж?!.. Заримдаа бас гай чирдэг ажээ!

Монгол улсын төрийн соёрхолт, соёлын гавьяат зүтгэлтэн Цэндийн Доржготов

1. Эхэд орсон дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

1. сөөнгөтөх	а. шаралхах
2. маймрах	б. дамжих
3. дэлсэх	с. заглах
4. улангасах	д. цохих
5. буухиалах	е. ярих

A. 1е. 2а. 3д. 4с. 5б.

B. 1а. 2с. 3д. 4е. 5б.

C. 1е. 2б. 3д. 4а. 5с.

D. 1а. 2б. 3д. 4е. 5с.

E. 1е. 2с. 3д. 4а. 5б.



2. Хам сэдвийн хувьд бусдаас өөр хэсгийг олоорой.
- Тэрсхэн хоёр ач нь дүрсгүйтэх нь ядарсан өвгөнд халгаатай ч, "тэсвэрлэе" гэж хатуу шийдсэн учир нүд аньж, эрх эргүүлсээр өдрийг барна.
 - Та муу хоёр золигт уг нь бөхийн удам гарцаагүй байх ёстой сон гэж сөөнгөтөхөд эцэнхий нүүрт нь удахгүй учрах үхлээ мартсан баяр гийнэ.
 - Нөгөө хоёрын гар нь өвдсөн бололтой "ёо ёо" гээд гараа үлээцгээн, унан тусан хөхрөлдөж хөхрөлдөж, сээрээ хугалж дийлэлгүй гарцгаав.
 - Дүрсгүй, уйдсан хоёр ач нь "Өвөө та одоо ийм бярттай байгаа юм чинь залуудаа ёстой аварга бөх байсан байх аа" гээд толгой сэгсрэн магтлаа!
 - Хоёр ач чинь төмрийн хөрөөгөөр хөрөөдөж, хөрөөдсөн ормоо царцуу өөхөөр шавж тогтоогоод чамайг дамшиглах гэж түмпэнд тавьчихсан юм.
3. Тодруулсан хэсгийн хэв маягийг тодорхойлоорой.
- Хэрүүл болж байгааг цаг хугацааны дарааллаар хүүрнэсэн тул хүүрнэмж
 - Хэрүүл хэрхэн болж байгааг нэгэн цагт тоочин дүрсэлсэн учир тоочимж
 - Хэрүүл үүсэх шалтгааныг дүгнэж эргэцүүлж байгаа тул эргэцүүлэмж
 - Хэрүүл хэрхэн, юунаас болж байгааг тайлбарласан тул тайлбарламж
 - Хэрүүл үүсэх шалтгаан болоод үйл явдлыг дүрсэлсэн тул эргэцүүлэмж, тоочимж хосолсон
4. Өгүүллэгийн "Хоёр биеэ санасан өвгөн эмгэн хоёр дөрвөн ханатаа юуны түрүү босгов" хэсэгт аль дүрслэх ур маягийг ашигласан байна вэ?
- ихэсгэл
 - хэтрүүлэл
 - төлөөлөл
 - багасгал
 - адилтгал
5. Өвгөн Сэдваанчиг "сээр цохих"-той хамааралгүй хэсэг аль нь вэ?
- Аав аа, та яасан мундаг юм бэ гэж дуу алдана.
 - Чи муу төрийн хутгуур гэж цоллов.
 - Бид хоёр таван сарвуугаа бяцартал зөндөө гөвшөөд хугалж дийлээгүй юм шүү дээ?!
 - Удалгүй өвгөний лагшин гэнэт чилээрхэв.
 - Өвгөн дуугарахгүй буруу харж хэвтсэн чигтээ хэд хоноод амьсгал хураав.
6. Өгүүллэгийн "Чи муу хөрөөдсөн сээр хуга шаачхаад, зөнөгөө мэдэхгүй онгирч, хүүхдүүдийнхээ элэг доог болсноо одоо мэдэж ав!.." хэсгээр Сэрээдэнийн сэтгэлийн ямар өнгө аяс илэрч байна вэ?
- хоролхож шаралхсан
 - уурлаж бухимдсан
 - гомдож тунирхсан
 - дургүйцэж ундууцсан
 - өширхөж хорссон
7. Өгүүллэгийн орчноос бусдаасаа ялгаатай байгааг сонгоорой.
- Яваад бай, яваад бай! Давшаад бай, давшаад бай гэж ташуур өгч, тохуурхаад гарч одов.
 - Хүүхдүүдээ дэс дараалан зөвтгөж, өвгөн тэр болгонд, дэс дараалан буруудна.
 - Эмгэн "Дулаан газар өвөлжинө" гээд охиныдоо төвлөж, өвгөн "Малын амьсгаа, хөх өтгөнөөсөө хол үхэхгүй" гэж уулын мухрын өвөлжөөнд, отгон хүүгийн дээ хоцорчээ.
 - Сүүлийн жилүүдэд хоёул яльтай яльгүй юмнаас болж үг сөргөлцөж, муудалцана.
 - Тараг сүү дэлгэрэх үед эмгэн Сэрээдэнэ хөдөөлж, хоёр биеэ санасан өвгөн эмгэн хоёр дөрвөн ханатаа юуны түрүү овойлгов.
8. Өгүүллэгийн "Сэдваанчиг"-ийн дүрд тохирохыг сонгоорой.
- Тэр бол бие муутай үхэхээ хүлээж байж эмгэнтэйгээ ч таарамжгүй муу хүн
 - Тэр бол хугархай сээр цохичоод худал хэнхэлээж байгаа онгироо хүн
 - Тэр бол сэтгэл санаагаар өөдөлж, уруудсан бие тааруу настай хүн
 - Тэр бол эр бяр хариагүй байгаа гэдэгтээ итгэсэн бардам хүн
 - Тэр бол хугархай сээр цохиж хугалснаа ч мэддэггүй гэнэн тэнэгдүү хүн
9. Бэр нь баяр хөөр болон гүйх болсон шалтгаан юу вэ?
- Өвөө нь бяр чадал муутай дөнгөж өндийх төдий байсан болохоор
 - Зэлүүд нутагт ховор юмны нэгийг үзсэн болохоор
 - Төсөөлөөгүй хөгшин хүнээс тийм их бяр гарсан болохоор
 - Эзгүй ууланд өвөлжингөө уйссан болохоор
 - Хоёр ач тэр сээрийг хөрөөдсөн гэдгийг сүүлдэж мэдсэн болохоор

10. Өгүүллэгийн гол санааг илэрхийлсэн хэсэг аль нь вэ?

- A. Өвгөн нэг л хачин, сэжигтэй, таг чимээгүй болчихсон гэнэ. Тэр дахиж үг унагасангүй. Хэвтээд өгч. Удалгүй өвгөний лагшин гэнэт чилээрхэв.
- B. "Би юунд тийм хэрэг хийв ээ?" гэж уйлаад, гэртээ хүн ороход дургүйцэж, гав ганцаар мэгшихийг хичээнэ.
- C. Үйл Эр хүнийг эр чадлаар нь басамжилна гэдэг ийм аюултай ажээ.
- D. "Явах" гэж морио эмээллэчихсэн өвгөнд хөндлөнгийн ялимгүй шалтаг таарвал түүнийг аваад залрах эгзэгтэй мөч отоож байсныг эмгэн анзаарсангүй.
- E. Тэр сээр чинь хөрөөдөөгүй сээр байсан юм. Би ууртаа чамайг дийлэх гэж хөрөөдсөн сээр гэж худал хэлсэн юм.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

[30 0100]

Санамж:

- Даалгавар тус бүрийн зааврыг анхааралтай уншиж гүйцэтгээрэй.
- Даалгаврын хариуг шалгалтын дэвтрийн зохих зайд бичиж тэмдэглээрэй.
- Даалгавар бүрийн оноо харилцан адилгүй болно.

2.1. Дараах шүлгийг уншин зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай үгийг олж зөв болгон зассан тохиолдол тус бүр 1 оноо [5 оноо]

Намаржаандаа очихуй

Өвсөнд зассан үүрэнд гурван өндөг цайрна
Гурван цоохор өндгөө саатуулаад
Эх болтой шувуу эгц дээр нь жиргэнэ
Даль жирвэлзүүлэн агаарт тогтох тэр шувуу
Тэнгэрээс зүүсэн эсгий үнэг шиг харагдана.
Үнэгийг тэнгэрт тогтоосон үл үзэгдэх утсыг тастах гэсэн мэт
Хорон санаат эмгэн саран үүлэнд нуугдаж гэтнэ.
Нурж дарагдсан хуучин худаг хонхойно
Наана нь чулуун онгоц ус царайчилсан морь шиг тонгойно
Тэр онгоцонд гурван чулуу цайрна
Түүнийг би ус дүүргэсэн онгоцны ёроолоос
Амаараа үмхэн шүүрж тоглодог байсан юм.
Хагссан онгоцны ёроол дахь гурван цагаан чулуу
Хар багадаа энд орхиод явсан миний бага нас байна.
Өвөөгийн гэрийн буйр эдгээд, өвс ногоо ургажээ
Өвөг эмгээ үгүйлдэг сэтгэл ингэж эдэгсэн бил үү?
Эзгүй буйр, уяаны шон дээр өвөөлж суугаад донгодно...

Алдаатай бичсэн үг
Засаж бичсэн үг

Мө.Батбаяр “Мөнгөн бүдда авсан өдөр” 2023 номын 22 дугаар тал

2.2. Дараах цогцолборыг уншаад кирилл бичигт хөрвүүлээрэй.

[5 0100]

0-1 алдвал 5 оноо, 2-3 алдвал 4 оноо, 4-5 алдвал 3 оноо, 6-7 алдвал 2 оноо, 8-9 алдвал 1 оноо, 10-с дээш алдвал 0 оноотой болно.

[illegible]

2.3. Монголын шинэ цагийн залуус өөрийн мэдлэг чадвар, бие бялдар, оюун санаагаа хөгжүүлж бүхий л салбарт хүч үзэн улс эх орон, тив дэлхийд алдраа цуурайтуулж явна. Та ч мөн адил тэдний нэг нь байхаар хичээж байгаа гэдэгт бид огтхон ч эргэлзэхгүй байна.

Түүний тулд хэрхэн буйгаа “**Миний зорилго**” сэдвийн дор сийрүүлэн бичнэ үү.

Ингэхдээ өөрийн амьдрал, хүсэл зорилгод тулгуурлан, хөдөлшгүй болоод үзэл бодлоо бүрэн дэмжихүйц баримт сонгон, шалтгаан - үр дүнгийн нягт холбоотой бичихээс гадна бүтэц, өнгө аяс, сэдэв агуулгын харьцааг оновчтой гаргаж, дүр дүрслэл, үг сонголтыг зөв, оновчтой ашиглан хэл зүй, найруулга, зөв бичгийн дүрмийн алдаагүй, уншигчдад сонирхолтой байх зэргийг тооцоорой.

Бичгийн соёл оноонд нөлөөлөхийг анхаарна уу.

/Үгийн тоо 200-250/

[20 очоо]



Даалгавар	Зөв бичих чадвар	Үндэсний бичгээр унших чадвар	Эх зохион найруулах чадвар							
			Сэдэв ба зорилго	Бүтэц	Эшлэл баримт	Бичлэгийн хэлбэр төрөл	Хэл зүй, найруулга	Үгийн тоо	Зөв бичгийн дүрэм	Бичгийн соёл
Авбал зохих оноо	5	5	5	3	2	2	3	1	3	1
Авсан оноо										

Дүгнэж оноожуулсан багшийн код